



СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 02 сарын 27 өдөр

Дугаар А/36

Улаанбаатар хот

Аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн албан тушаалын ангилал, зэрэглэл, дотоод зохион байгуулалт, орон тооны дээд хязгаарт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн "Төрийн захиргааны албан тушаалын ангилал зэрэглэл, албан тушаалын жагсаалт батлах тухай" 487 дугаар тогтоол, Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай" 276 дугаар тогтоол, "Стандарт, хэмжил зүйн газрын Үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай" Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 32 дугаар тушаал, "Стандарт, хэмжил зүйн газрын Үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Монгол Улсын Шадар сайдын 2023 оны 5 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Стандарт, хэмжил зүйн газрын Үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт орсон, төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан аймаг дахь Стандарт, хэмжил зүйн зүйн хэлтсийн албан тушаалын ангилал, зэрэглэлд нэмэлт, өөрчлөлт оруулан 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2. Архангай аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дотоод зохион байгуулалт, орон тооны дээд хязгаарыг 2 дугаар, Баян-Өлгий аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дотоод зохион байгуулалт, орон тооны дээд хязгаарыг 3 дугаар, Баянхонгор аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дотоод зохион байгуулалт, орон тооны дээд хязгаарыг 4 дүгээр, Булган аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дотоод зохион байгуулалт, орон тооны дээд хязгаарыг 5 дугаар, Говь-Алтай аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дотоод зохион байгуулалт, орон тооны дээд хязгаарыг 6 дугаар, Говьсүмбэр аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дотоод зохион байгуулалт, орон тооны дээд хязгаарыг 7 дугаар, Дархан-Уул аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дотоод зохион байгуулалт, орон тооны дээд хязгаарыг 8 дугаар, Дорноговь аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дотоод зохион байгуулалт, орон тооны дээд хязгаарыг 9 дүгээр, Дорнод аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дотоод

зохион байгуулалт, орон тооны дээд хязгаарыг 10 дугаар, Дундговь аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дотоод зохион байгуулалт, орон тооны дээд хязгаарыг 11 дүгээр, Завхан аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн бүтцийн дотоод зохион байгуулалт, орон тооны дээд хязгаарыг 12 дугаар, Орхон аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дотоод зохион байгуулалт, орон тооны дээд хязгаарыг 13 дугаар, Өвөрхангай аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дотоод зохион байгуулалт, орон тооны дээд хязгаарыг 14 дүгээр, Өмнөговь аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дотоод зохион байгуулалт, орон тооны дээд хязгаарыг 15 дугаар, Сүхбаатар аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дотоод зохион байгуулалт, орон тооны дээд хязгаарыг 16 дугаар, Сэлэнгэ аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дотоод зохион байгуулалт, орон тооны дээд хязгаарыг 17 дугаар, Төв аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дотоод зохион байгуулалт, орон тооны дээд хязгаарыг 18 дугаар, Увс аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дотоод зохион байгуулалт, орон тооны дээд хязгаарыг 19 дүгээр, Ховд аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дотоод зохион байгуулалт, орон тооны дээд хязгаарыг 20 дугаар, Хөвсгөл аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дотоод зохион байгуулалт, орон тооны дээд хязгаарыг 21 дүгээр, Хэнтий аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дотоод зохион байгуулалт, орон тооны дээд хязгаарыг 22 дугаар хавсралтаар тус тус нэмэлт, өөрчлөлт оруулан баталсугай.

3. Албан тушаалын ангилал, зэрэглэлд нэмэлт, өөрчлөлт орсон, шинээр нэмэгдсэн чиг үүргийн хүрээнд бий болсон албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулан батлуулахыг Захиргаа, удирдлагын газарт, хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Бүтцийн дотоод зохион байгуулалт, орон тооны дээд хязгаарт өөрчлөлт орсонтой холбогдуулан цалингийн санд багтаан зохих арга хэмжээ авч ажиллахыг аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга нарт даалгасугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (С.Батбаатар)-т даалгасугай.

6. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны А/118 тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Б.УУГАНБАЯР



Стандарт, хэмжил зүйн газрын даргын
 2023 оны 02 дугаар сарын 27 өдрийн
 А/36 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



АЙМАГ ДАХЬ СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ЗҮЙН
 ХЭЛТСИЙН АЛБАН ТУШААЛЫН АНГИЛАЛ, ЗЭРЭГЛЭЛ

№	Албан тушаалын нэр	Албан тушаалын зэрэглэл	Албан тушаалын ангилал
1	Хэлтсийн дарга	T3-4	Ахлах түшмэл
2	Хэмжил зүйн хяналтын улсын байцаагч	T3-7	Дэс түшмэл
3	Сорьцын хяналтын улсын байцаагч бөгөөд Ахлах мэргэжилтэн /Хүний нөөц, дотоод хяналтын асуудал хариуцсан/		
4	Бүтээгдэхүүн, баталгаажуулалтын мэргэжилтэн		
5	Хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын мэргэжилтэн	T3-9	
6	Мэргэжилтэн /Сургалт, мэдээлэл, салбар сан, архив бичиг хэрэг/	T3-9	
7	Нягтлан бодогч	TY-8	
8	Хэмжүүр баталгаажуулалтын техникч	TY-5	
9	Лабораторийн эрхлэгч	TY-8	
10	Лабораторийн шинжээч-дээж хүлээн авагч /химич, нян судлал, хорио цээр/	TY-6	
11	Үнэт металл хайлагч	TY-6	
12	Лаборант /шил угаагч/	TY-4	
13	Нярав	TY-4	
14	Жолооч	TY-3	
15	Үйлчлэгч	TY-1	

Стандарт, хэмжил зүйн газрын даргын
2023 оны 02 дугаар сарын 27 өдрийн
А/ЗБ: дугаар тушаалын 10 дугаар хавсралт



Дорнод аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн
дотоод зохион байгуулалт, орон тооны дээд хязгаар

№	Албан тушаалын нэр	Орон тоо
1	Хэлтсийн дарга	1
2	Хэмжил зүйн хяналтын улсын байцаагч	1
3	Сорьцын хяналтын улсын байцаагч бөгөөд Ахлах мэргэжилтэн /Хүний нөөц, дотоод хяналтын асуудал хариуцсан/	1
4	Бүтээгдэхүүн, баталгаажуулалтын мэргэжилтэн	2
5	Хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын мэргэжилтэн	3
6	Мэргэжилтэн /Сургалт, мэдээлэл, салбар сан, архив, бичиг хэрэг/	1
7	Нягтлан бодогч	1
8	Хэмжүүр баталгаажуулалтын техникч	1
9	Лабораторийн эрхлэгч	1
10	Лабораторийн шинжээч- дээж хүлээн авагч /химич, нян судлал, хорио цээр/	4
11	Лаборант /шил угаагч/	2
12	Нярав	1
13	Жолооч	1
14	Үйлчлэгч	1
	НИЙТ	21 хүртэл